



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 01 сарын 19 өдөр

Дугаар А/04

Улаанбаатар хот

“Улаанбаатар травел экспо” арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 02/09 тогтоолоор батлагдсан “Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 4.3.1 дахь заалт, 02/10 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 3.4.1.2 дахь хэсэг, Нийслэлийн Засаг даргын 2022 оны “Дүрэм шинэчлэн батлах тухай” А/155 дугаар захирамжаар батлагдсан газрын дүрмийн 4.1.8, 7.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлэх, аялал жуулчлалын салбарт бараа бүтээгдэхүүн нийлүүлж, үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудыг нэг цэгээс хэрэглэгчидтэй уулзуулж, аялагч, амрагчдад аяллын талаарх мэдээ, мэдээлэл авах боломжийг бүрдүүлэх зорилгоор “Улаанбаатар травэл экспо-2023” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнг Улаанбаатар Аялал жуулчлалын холбоо НҮТББ-тай хамтран 2022 оны 05 дугаар сарын 19-21-ний өдрүүдэд Мишээл Экспо ОУҮХТ-д зохион байгуулсугай.

2. “Улаанбаатар травэл экспо-2022” үндэсний аялал жуулчлалын үзэсгэлэн зохион байгуулах Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

3. Арга хэмжээ зохион байгуулах ажлын төлөвлөгөөг батлуулж, нэгдсэн удирдлагаар хангаж, ажлын үр дүнг танилцуулахыг Ажлын хэсэг /В.Батчимэг/-т даалгасугай.

ДАРГ *D. Batsu* Д.БАТСҮХ



1150500024

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын
даргын 2023 оны 01 сарын 19 өдрийн
А/04 дугаар тушаалын хавсралт

“УЛААНБААТАР ТРАВЭЛ ЭКСПО-2023” ҮНДЭСНИЙ АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
ҮЗЭСГЭЛЭН ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч:	В.Батчимэг	Бодлогын хэрэгжилтийн хэлтсийн дарга
Гишүүд:	Б.Ербахыт	Улаанбаатар аялал жуулчлалын холбоо НҮТББ-ын менежер /зөвшилцсөнөөр/
	Ч.Болорхүү	Нона Фамили ХХК-ний гүйцэтгэх захирал /зөвшилцсөнөөр/
	Б.Цолмонгэрэл	Хэвлэл мэдээлэл, олон нийт хариуцсан мэргэжилтэн
	О.Хандам	Жуулчны Мэдээлэл, сурталчилгааны төвүүд хариуцсан ажилтан
	Г.Дамдинсүрэн	Мэдээллийн технологи, цахим хөгжил хариуцсан ажилтан
Нарийн бичгийн дарга:	Т.Туул	Гадаад хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтэн

--oOo--